



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын Насан туршийн боловсрол төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/176/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас:70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Аудитор: Н.Дэмбэрэлдорж
Утас: 99299027
Цахим хаяг: ndembee.@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.5.1 Төсвийн төлөвлөлт	10
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	10
3.5.3 Нэмэлт төсөв	11
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	11
4.1 Ерөнхий зүйл.....	11
4.2 Материаллаг байдал	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
4.5.1 Завсрын аудитын талаар.....	12
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	13
5.1 Залруулсан алдаа.....	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУГ	Боловсрол шинжлэх ухааны газар
НТБТ	Насан туршийн боловсрол төв



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

**ЖАРГАЛАНТ СУМЫН
НАСАН БОЛОВСРОЛ ТӨВИЙН
ЗАХИРАЛ Д.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА**

2023.02.06 № 02/11
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын Насан туршийн боловсрол төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын Насан туршийн боловсрол төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт онцлох ажил гүйлгээ байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсноор тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тус төвийн ажлын байрыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 21-07-034/66 тоот дүгнэлтээр Барилгын тухай хуулийн 11,1,5-д "барилга байгууламж ашиглалтын явцад хүний эрүүл мэнд, амь насанд хохирол учруулахгүй, галд тэсвэртэй, цахилгаан хангамж, эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй байх" гэсэн заалтыг хангахгүй байна гэсэн дүгнэлт гаргасан ч хөрөнгө оруулалтын асуудал шийдвэрлэгдээгүй тул ашигласаар байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

021020104

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9,054,325.36	9,209,392.00
33	АВЛАГА	63,100.36	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	63,100.36	-
35	БАРАА МАТЕРИАЛ	8,991,225.00	9,209,392.00
354	Хангамжийн материал	8,991,225.00	9,209,392.00
35420	Аж ахуйн материал	8,991,225.00	9,209,392.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	19,962,061.02	14,783,108.30
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	19,962,061.02	14,783,108.30
392	Биет хөрөнгө	19,742,061.02	14,645,608.30
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	39,186,631.00	39,186,631.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(29,195,761.36)	(31,792,854.04)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,034,290.00	22,034,290.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,283,098.62)	(14,782,458.66)
393	Биет бус хөрөнгө	220,000.00	137,500.00
39301	Програм хангамж	330,000.00	330,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(110,000.00)	(192,500.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	29,016,386.38	23,992,500.30
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	28,046,486.38	23,223,600.30
51	Засгийн газрын хувь оролцоо	28,046,486.38	23,223,600.30
512	Хуримтлагдсан үр дүн	28,046,486.38	23,223,600.30
51210	Өмнөх үеийн үр дүн	28,046,486.38	28,046,486.38
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	28,046,486.38	23,223,600.30

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	125,497,617.00	128,051,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,209,417.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	19,209,417.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,209,417.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	19,209,417.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	106,288,200.00	128,051,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	106,288,200.00	126,140,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	106,288,200.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	107,064,827.00	132,874,286.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	107,064,827.00	132,874,286.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	106,328,727.00	132,874,286.08

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	89,240,446.00	107,387,206.49
210101	Үндсэн цалин	67,022,783.00	87,744,153.49
210102	Нэмэгдэл	17,424,687.00	15,896,354.00
210104	Урамшуулал	4,792,976.00	3,746,699.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,131,782.16	13,165,293.87
210201	Тэтгэврийн даатгал	8,090,313.22	9,247,193.25
210202	Тэтгэмжийн даатгал	2,206,241.67	1,662,998.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	713,923.55	859,039.30
210204	Ажилгүйдлийн даатгал	121,303.72	170,627.59
2104	Хангамж, бараа материалын зардал	1,030,000.00	846,333.00
210401	Бичиг хэрэг	89,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	714,900.00	553,000.00
210404	Ном, хэвлэл	87,500.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	65,600.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	73,000.00	293,333.00
2105	Нормативт зардал	1,977,150.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	90,900.00	-
210502	Хоол, хүнс	1,710,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	176,250.00	-
2107	Томилолт, зочны зардал	9,900.00	-
210702	Дотоод албан томилолт	9,900.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,939,448.84	11,475,452.72
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,189,750.00	2,171,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,749,698.84	5,178,952.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	736,100.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	736,100.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	736,100.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	18,432,790.00	(4,822,886.08)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	106,288,200.00	128,051,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	106,288,200.00	128,051,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	106,288,200.00	126,140,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	106,288,200.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	106,288,200.00	128,051,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	106,288,200.00	128,051,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	102,342,100.00	128,051,400.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	88,313,300.00	107,101,400.00
210101	Үндсэн цалин	61,585,000.00	96,488,592.00
210102	Нэмэгдэл	21,527,600.00	6,339,042.00
210104	Урамшуулал	5,200,700.00	4,273,766.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,127,700.00	13,388,000.00

210201	Тэтгэврийн даатгал	7,623,200.00	9,103,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	876,100.00	1,067,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	700,900.00	860,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	175,200.00	214,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,752,300.00	2,142,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,086,300.00	800,000.00
210401	Бичиг хэрэг	89,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	718,300.00	800,000.00
210404	Ном, хэвлэл	140,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	65,600.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	73,400.00	-
2105	Нормативт зардал	254,000.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	90,500.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	163,500.00	-
2107	Томилолт, зочны зардал	9,900.00	-
210702	Дотоод албан томилолт	9,900.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,550,900.00	6,762,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,550,900.00	3,762,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,946,100.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,946,100.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,946,100.00	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	768,900.00		14,475,069.38	15,243,969.38
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	768,900.00		28,046,486.38	28,815,386.38
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
17	Тайлант үеийн үр дүн			-4,822,886.08	-4,822,886.08
18				
19	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	768,900.00		23,223,600.30	23,992,500.30

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	128,051,400.00	128,051,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	128,051,400.00	128,051,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	128,051,400.00	128,051,400.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	107,101,400.00	107,101,400.00
210101	Үндсэн цалин	102,838,000.00	96,488,592.00
210102	Нэмэгдэл	1870,400.00	6,339,042.00
210104	Урамшуулал	2393,000.00	4,273,766.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13388000.00	13388000.00
210201	Тэтгэврийн даатгал	9103700.00	9103700.00
210202	Тэтгэмжийн даатгал	1067600.00	1067600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	860300.00	860300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	214300.00	214300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2142100.00	2142100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7562000.00	7562000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,000.00	800,000.00
210404	Ном, хэвлэл	3,000,000.00	3,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,762,000.00	3,762,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	128,051,400.00	128,051,400.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	126,140,400.00	126,140,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	126,140,400.00	126,140,400.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,911,000.00	1,911,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	1,911,000.00	1,911,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Жаргалант сумын Насан туршийн боловсрол төв нь Багш нарын мэдлэг чадвар, ажилдаа хандах хандлагыг сайжруулан суралцагчид, иргэдэд олгох үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдэд шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь хүргэх, хэрэгцээт боловсролыг нь тасралтгүй олгох нөхцөлөөр хангах, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах. "Хүний төлөө сайн үйлс түгээгч байгууллага" болоход оршино гэсэн зорилт дэвшүүлэн ажилласан байна Үүнд:

Боловсрол нөхөн олгох сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, суралцагчдад эрүүл аюулгүй, сэтгэл зовнилгүйгээр суралцахад нь туслах. хүрэгчдэд хийх сургалтын чанар, үр өгөөж, хэлбэр, арга барилыг сайжруулах оновчтой зохион байгуулж иргэдэд ирээдүйдээ итгэлтэй, өөртөө шүүмжлэлтэй, хууль ёсыг дээдлэх хандлага төлөвшүүлэх чиглэлийг баримтлах.

Ажлын цагийг үр бүтээлтэй ашигладаг, харилцан бие биеэ хүндэлдэг, байгууллагын зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд хүн бүр тэгш, хариуцлага хүлээж хэрэгжүүлдэг, харилцаа, ёс зүй хэм хэмжээг сахин байгууллагын соёлыг дээшлүүлэх.

Төсөв, санхүүг хуулийн дагуу үр дүнтэй зарцуулж суралцагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэн ажиллаж, суралцах орчин нөхцөлийг сайжруулах.

Энэхүү хичээлийн жилд сургалтын орчноо сайжруулах, өргөжүүлэх, төсөл хөтөлбөр, орон нутгийн аж ахуй нэгж, байгууллагатай хамтран ажиллах зорилтуудыг тавин ажиллаж байна

Ховд аймгийн Насан туршийн боловсрол төв нь Аймгийн Засаг даргын 2013 оны 11 сарын 22 -ны өдрийн А/ 425 тоот захирамжийн дагуу бие даасан төв болон 16 сум тус бүрт Насан туршийн боловсролын нэгжтэй үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн .2022 онд аймгийн Насан туршийн боловсрол төв нь захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, дунд бүлгийн багш, бага ангийн багш, үйлчилгээний ажилтан, гэрээгээр ня-бо гэсэн 7 орон тоотойгоор ажил үүргээ гүйцэтгэж ажиллаа.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх Төрийн хэмнэлтийн тухайн хууль шинээр батлагдаж мөрдөгдөж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Боловсролын тухай хууль,Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж өмч хөрөнгийн тооллогыг хагас бүтэн жилээр хийж илтгэх хуудсаар баталгаажуулсан байна. .

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын НТБТ нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жаргалант сумын НТБТ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,0 сая төгрөгөөр буюу 17,4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	63.10		-63.10
Бараа материал	8,991.20	9,209.40	218.20
Үндсэн хөрөнгө	19,962.06	14,783.10	-5,178.96
Нийт хөрөнгө	29,016.36	23,992.50	-5,023.86
Өр төлбөр	201.00		-201.00
Засгийн газрын хувь оролцоо/Эздийн өмч/	28,815.38	23,992.50	-4,822.88
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн/	29,016.38	23,992.50	-5,023.88

Дээрх хүснэгтээс харахад Жаргалант сумын НТБТ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5023,6 мянган төгрөгөөр буурсан нь материаллаг нөлөө нь үндсэн хөрөнгийн данстай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 134.6 сая тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 6.6 сая төгрөгөөр бууруулж 128.0 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2022 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй эсвэл өмнөх оны төсвийн гүйцэтгэлд үндэслэснээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг тодотгоогүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 126,1 сая төгрөгийг улсын төсвөөс , 1,9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс олгосон байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 128,0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 128,0 сая төгрөг буюу 100,0 хувь зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71806/81834-Боловсролын стандарт, сургалтын үйл ажиллагаа	97,562.0	97,562.0	0.0	100.0
2	71806/81835- Сургалтын хэвийн үйлчилгээ	28,578.4	28,578.4	0.0	100.0
Нийт дүн		126,140.4	126,140.4	0.0	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жаргалант сумын НТБТ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн бараа материалтай холбоотой зөвлөмж тусгасан.

Аудитыг аудитор Н.Дэмбэрэлдорж 2023 оны 01 дүгээр сарын 18-наас 01 дүгээр сарын 25-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогын 111,9 сая төгрөгөөс 1,5 хувиар буюу 1,6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 1,3 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс хугацаандаа оруулсан 133 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 13 байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Жаргалант сумын НТБТ-ийн 2022 онд завсрын аудит хийгээгүй, өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилтийг хянасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгөгдсөн Татварын ерөнхий хуулийн 28.5. “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсвэл цахимаар илгээх үүрэгтэй”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг И баримтаар баталгаажуулан ажиллах хяналтыг хэрэгжүүлээгүй зөвлөмж өгөгдсөн нь бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь

Акт	0	0	0	0	0
Албан шаардлага	0	0			
Зөвлөмж	1	1	1	1	100
Нийт дүн	1	1	1	1	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал нь няравд үйлчлэгчийн ажлыг хавсран гүйцэтгүүлж, цэвэрлэгээний бараа материалыг өөрөө бэлтгэж зарцуулсан дутагдлыг арилгах дотоод хяналтыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нярвын харилцах дансаар дамжуулан бараа материал бэлтгэдэг зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө

5.1 Заглуулсан алдаа

Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй

5.2 Зөвлөмж

5.2.1 Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлангийн жилд бараа материалыг бэлтгэхдээ няравын харилцах дансанд бэлэн мөнгө төвлөрүүлж гүйлгээ хийж төсвийн зарцуулалтанд тавих дотоод хяналтыг сулруулсан зөрчил илэрсэн.

Энэ нь "Төсвийн хуулийн 6,2,1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ" гэсэн заалтын дагуу бараа материалыг бэлтгэхдээ оны эхэнд тухайн аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж мөрдөж ажиллах

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Заглуулсан	Заглуулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Заглуулга хийгдээгүй	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/ мянган төгрөг/							
	Үүнээс							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	

Бараа материалыг худалдан бэлтгэхдээ гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн харилцах дансаар дамжуулан гүйлгээ хийж бэлтгэж хэвших	1	-					1	-
Дүн	1		-	-			1	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Алдаа илрээгүй	-	-	-	-	-	-	-	-
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Алдаа илрээгүй	-	-	-	-	-	-	-	-
Дүн								
Нийт дүн								

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: *[Signature]* Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР: *[Signature]* А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР: *[Signature]* Н.ДЭМБЭРЭЛДОРЖ

